



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Наран сумын хүн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: СБА-2022/74/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Баруун-Урт 2022 он</p>	<p>Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Нарантуяа Утас: 70518396 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Г.Даваа Утас: 70512123 Цахим хаяг: davaag@audit.gov.mn</p> <p>Аудитор: Б.Мөнхбамбар Утас: 70512127 Цахим хаяг: munkhbambarb@audit.gov.mn</p>
----------------------------------------------------------------------------------------------------	-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	12
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт	14
4.1 Төлбөрийн акт.....	Error! Bookmark not defined.
4.2 Албан шаардлага	Error! Bookmark not defined.
4.3 Зөвлөмж	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1. Аудитын санал дүгнэлт



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518398, Факс: 70518398
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2022.02.25 № 33

танай _____-ны № _____-т

СҮХБААТАР АЙМГИЙН НАРАН СУМЫН
ХҮН ЭМНЭЛГИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Б.ГАНТУЯА ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Наран сумын Хүн эмнэлгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Наран сумын Хүн эмнэлгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *М.Нарантуяа* М.НАРАНТУЯА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	24,578,505.53	120,368,118.39
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	7,587,196.46
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	7,587,196.46
3121	Төгрөг	00.00	7,587,196.46
31211	Төрийн сангийн харилцах	00.00	7,254,130.46
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	00.00	333,066.00
33	АВЛАГА	00.00	50,112,800.00
335	Бусад авлага	00.00	50,112,800.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	50,112,800.00
35	БАРАА МАТЕРИАЛ	24,578,505.53	62,668,121.93
351	Түүхий эд материал	2,484,425.53	20,204,934.73
35110	Тусгай зориулалттай материал	1,326,325.00	414,700.00
35130	Эм боох материал	1,158,100.53	19,790,234.73
354	Хангамжийн материал	21,014,500.00	34,983,187.20
35410	Бичиг хэргийн материал	740,990.00	667,100.00
35420	Аж ахуйн материал	15,497,822.00	13,567,460.00
35430	Сэлбэг хэрэгсэл	277,000.00	70,000.00
35440	Түлш, шатах тослох материал	2,872,540.00	712,500.00
35460	Хүнсний материал	1,626,148.00	807,520.00
35470	Бусад хангамжийн материал	00.00	19,158,607.20
35600	Мал амьтад	1,079,580.00	7,480,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	151,147,499.80	161,296,063.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	151,147,499.80	161,296,063.00
392	Биет хөрөнгө	149,229,499.80	159,378,063.00
39201	Барилга, байгууламж, орон сууц	120,138,170.00	120,138,170.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-29,525,983.16	-37,200,465.44
39203	Авто-тээврийн хэрэгсэл	32,560,000.00	31,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-9,317,500.00	-11,587,500.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	59,263,659.13	69,697,887.65
39206	Хуримтлагдсан элэгдэл	-44,820,946.49	-32,130,301.57
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	36,008,675.30	31,186,267.30
39208	Хуримтлагдсан элэгдэл	-21,741,745.45	-18,280,615.37
39214	Бусад үндсэн хөрөнгө	12,211,000.00	12,211,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-5,545,829.53	-6,156,379.57
393	Биет бус хөрөнгө	1,918,000.00	1,918,000.00
39301	Програм хангамж	1,070,000.00	1,070,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,070,000.00	-1,070,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	1,918,000.00	1,918,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	175,726,005.33	281,664,181.39
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	175,726,005.33	281,664,181.39
51	Засгийн газрын хувь оролцоо	175,726,005.33	281,664,181.39
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	162,289,096.51	162,289,096.51
51101	Өмч: - төрийн	162,289,096.51	162,289,096.51
512	Хуримтлагдсан үр дүн	-31,698,173.55	74,240,002.51
51210	Өмнөх үеийн үр дүн	-31,698,173.55	-31,698,173.55
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	105,938,176.06
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	45,135,082.37	45,135,082.37
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	175,726,005.33	281,664,181.39

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	352,597,432.06	668,495,791.95
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,723,543.06	91,232,245.95
120	Нийтлэг татварын бус орлого	5,723,543.06	91,232,245.95
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,723,543.06	91,232,245.95
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	5,723,543.06	91,232,245.95
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	50,691,389.00	268,796,346.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	296,182,500.00	308,467,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	15,276,439.00	158,220,306.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	8,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,157,339.00	149,830,306.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	119,100.00	390,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	25,322,500.00	47,101,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	25,322,500.00	47,101,100.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	10,092,450.00	63,474,940.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	10,092,450.00	63,474,940.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	366,079,608.36	562,557,615.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ	366,079,608.36	562,557,615.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	351,273,164.83	517,885,419.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	210,558,762.12	236,397,505.24
210101	Үндсэн цалин	140,809,022.13	136,151,156.54
210102	Нэмэгдэл	54,876,690.99	83,160,728.70
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	3,320,550.99
210104	Урамшуулал	14,873,049.00	13,765,069.01
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,801,755.95	30,818,398.30
210201	Тэтгэврийн даатгал	19,363,159.31	21,591,978.82
210202	Тэтгэмжийн даатгал	2,118,949.45	2,386,083.05
210203	ҮОМШО-ний даатгал	1,685,299.08	1,832,508.97
210204	Ажилгүйдлийн даатгал	421,050.33	426,550.02
210205	Эрүүл мэндийн даатгал	4,213,297.78	4,581,277.44
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,645,167.40	20,328,243.71
210301	Гэрэл, цахилгаан	4,197,599.00	4,671,491.37
210302	Түлш, халаалт	14,267,568.40	15,000,152.34
210303	Цэвэр, бохир ус	180,000.00	656,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,593,347.00	37,949,092.00
210401	Бичиг хэрэг	1,560,730.00	1,666,390.00
210402	Тээвэр, шатахуун	11,664,027.00	20,579,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,267,740.00	1,812,040.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,486,590.00	1,953,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	6,414,400.00
210408	Бараа материал аргасны зардал	1,614,260.00	5,522,862.00
2105	Нормативт зардал	36,593,901.90	143,330,123.20
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	31,479,353.90	130,461,395.20
210502	Хоол, хүнс	5,114,548.00	12,853,728.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	15,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,616,000.00	9,521,200.00
210604	Урсгал засвар	3,616,000.00	9,521,200.00
2107	Томилолт, зочны зардал	932,100.00	397,000.00
210702	Дотоод албан томилолт	932,100.00	397,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,839,305.00	15,523,351.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,971,305.00	15,523,351.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	868,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,692,825.46	23,620,506.15
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,390,410.00	3,372,930.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	19,302,415.46	20,247,576.15
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,806,443.53	44,672,196.29
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,625,000.00	25,798,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,625,000.00	25,798,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	812.60	18,873,696.29
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	812.60	18,873,696.29
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	13,180,630.93	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,180,630.93	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-13,482,176.30	105,938,176.06
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-13,482,176.30	105,938,176.06

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	162,289,096.51	45,135,082.37	-18,215,997.25	00.00	189,208,181.63
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	162,289,096.51	45,135,082.37	-18,215,997.25	00.00	189,208,181.63
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-13,482,176.30	00.00	-13,482,176.30
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	162,289,096.51	45,135,082.37	-31,698,173.55	00.00	175,726,005.33
D01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	162,289,096.51	45,135,082.37	-31,698,173.55	00.00	175,726,005.33
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	162,289,096.51	45,135,082.37	-31,698,173.55	00.00	175,726,005.33
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	105,938,176.06	00.00	105,938,176.06
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	162,289,096.51	45,135,082.37	74,240,002.51	00.00	281,664,181.39

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	346,873,889.00	527,150,746.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	346,873,889.00	527,150,746.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	296,182,500.00	308,467,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	15,276,439.00	158,220,306.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	8,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,157,339.00	149,830,306.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	119,100.00	390,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	25,322,500.00	47,101,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	25,322,500.00	47,101,100.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	10,092,450.00	13,362,140.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	10,092,450.00	13,362,140.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	345,953,889.00	515,119,549.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	345,953,889.00	515,119,549.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	331,147,445.47	470,447,353.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	210,558,762.12	236,397,505.24
210101	Үндсэн цалин	140,809,022.13	136,151,156.54
210102	Нэмэгдэл	54,876,690.99	83,160,728.70
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	3,320,550.99
210104	Урамшуулал	14,873,049.00	13,765,069.01
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,801,755.95	30,818,398.30
210201	Тэтгэврийн даатгал	19,363,159.31	21,591,978.82
210202	Тэтгэмжийн даатгал	2,118,949.45	2,386,083.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,685,299.08	1,832,508.97
210204	Ажилгүйдлийн даатгал	421,050.33	426,550.02
210205	Эрүүл мэндийн даатгал	4,213,297.78	4,581,277.44
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,321,687.40	18,168,203.71
210301	Гэрэл, цахилгаан	4,197,599.00	4,671,491.37
210302	Түлш, халаалт	16,944,088.40	12,840,112.34
210303	Цэвэр, бохир ус	180,000.00	656,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,126,487.00	33,679,790.00
210401	Бичиг хэрэг	1,548,620.00	1,592,500.00
210402	Тээвэр, шатахуун	11,664,027.00	20,579,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,567,740.00	1,812,040.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,346,100.00	2,000,000.00

Наран сумын хүн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	7,695,650.00
2105	Нормативт зардал	32,011,098.00	123,346,055.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	25,780,048.00	113,932,105.00
210502	Хоол, хүнс	5,231,050.00	8,213,950.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	1,200,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,227,500.00	10,109,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	207,500.00	50,000.00
210602	Тавилга	20,000.00	00.00
210604	Урсгал засвар	4,000,000.00	10,059,200.00
2107	Томилолт, зочны зардал	932,100.00	397,000.00
210702	Дотоод албан томилолт	932,100.00	397,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,050,005.00	15,537,351.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,182,005.00	15,537,351.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	868,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,118,050.00	1,993,850.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,118,050.00	1,993,850.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,806,443.53	44,672,196.29
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,625,000.00	25,798,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,625,000.00	25,798,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	812.60	18,873,696.29
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	812.60	18,873,696.29
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	13,180,630.93	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,180,630.93	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	920,000.00	12,031,196.46
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	920,000.00	4,444,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	920,000.00	4,444,000.00
2200	Дотоод эх үэсвэрээр	920,000.00	4,444,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	920,000.00	4,444,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-920,000.00	-4,444,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	7,587,196.46
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	7,587,196.46

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	373,158,100.00	342,802,613.25
21	УРСГАЛ ЗАРДАЛ	373,158,100.00	342,802,613.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	369,758,100.00	339,404,113.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	222,830,200.00	216,475,208.24
210101	Үндсэн цалин	137,731,600.00	133,163,119.54
210102	Нэмэгдэл	66,254,700.00	66,226,468.70
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,788,000.00	3,320,550.99
210104	Урамшуулал	14,055,900.00	13,765,069.01
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,027,700.00	27,922,860.30
210201	Тэтгэврийн даатгал	21,834,400.00	18,696,440.82
210202	Тэтгэмжийн даатгал	2,298,400.00	2,386,083.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,838,500.00	1,832,508.97
210204	Ажилгүйдлийн даатгал	460,000.00	426,550.02
210205	Эрүүл мэндийн даатгал	4,596,400.00	4,581,277.44
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,640,200.00	18,168,203.71
210301	Гэрэл, цахилгаан	6,890,200.00	4,671,491.37
210302	Түлш, халаалт	27,750,000.00	12,840,112.34
210303	Цэвэр, бохир ус	2,000,000.00	656,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,430,000.00	23,334,540.00
210401	Бичиг хэрэг	1,600,000.00	1,592,500.00
210402	Тээвэр, шатахуун	16,530,000.00	16,530,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,800,000.00	1,712,040.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,000,000.00	2,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,500,000.00	1,500,000.00
2105	Нормативт зардал	21,300,000.00	21,021,900.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	15,100,000.00	14,821,900.00
210502	Хоол, хүнс	5,000,000.00	5,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,200,000.00	1,200,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,630,000.00	14,553,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,500,000.00	2,494,000.00
210602	Тавилга	2,000,000.00	2,000,000.00
210604	Урсгал засвар	10,130,000.00	10,059,200.00
2107	Томилолт, зочны зардал	1,800,000.00	397,000.00
210702	Дотоод албан томилолт	1,800,000.00	397,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,100,000.00	15,537,351.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,100,000.00	15,537,351.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2000000.00	1993850.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	1,993,850.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	#REF!	#REF!
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,400,000.00	3,398,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,400,000.00	3,398,500.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	373,158,100.00	350,056,743.71
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	308,467,200.00	308,467,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	308,467,200.00	308,467,200.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	46,770,200.00	28,227,403.71
132001	Орон нутгийн төсвөөс	46,770,200.00	28,227,403.71
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	17,920,700.00	13,362,140.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	17,920,700.00	13,362,140.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	7,254,130.46
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	18.00	18.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	11.00	11.00
620003	Үйлчлэх ажилтан	06.00	06.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		157,887,240.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		157,887,240.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		135,487,240.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		19,922,297.00
210101	Үндсэн цалин		2,988,037.00
210102	Нэмэгдэл		16,934,260.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		2,895,538.00
210201	Тэтгэврийн даатгал		2,895,538.00
2104	Хангамж, бараа материалын зардал		10,345,250.00
210402	Тээвэр, шатахуун		4,049,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		100,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		6,195,650.00
2105	Нормативт зардал		102,324,155.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		99,110,205.00
210502	Хоол, хүнс		3,213,950.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		22,400,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		22,400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		22,400,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	158,220,306.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		158,220,306.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		8,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		149,830,306.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		390,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)-(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		333,066.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Наран сумын хүн эмнэлгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шилэн данс, үндсэн хөрөнгө, авлагатай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Мөнхбамбар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Наран сумын хүн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 1 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Наран сумын Хүн эмнэлэг нь “Хүн амд эмнэлгийн тусламжийг жигд хүртээмжтэй, чанарын өндөр түвшинд гүйцэтгэхийг эрхэмлэнэ” гэсэн эрхэм зорилготой байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Наран сумын хүн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 366.1 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 3.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 2.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Наран сумын хүн эмнэлгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 105.9 сая төгрөгөөр буюу 60 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.00	7.6	7.6
Авлага	0.00	50.1	50.1
Бараа материал	24.6	62.6	38.0
Үндсэн хөрөнгө	151.1	161.3	10.2
Нийт хөрөнгө	175.7	281.6	105.9
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	175.7	281.6	105.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	175.7	281.6	105.9

Авлага дансны үлдэгдэл 50.1 сая төгрөг болж өссөн нь эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт олгогдоогүй нь нөлөөлжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 62.6 сая төгрөг болж 38.0 сая төгрөгөөр өсжээ. Энэ нь Коронавирус цар тахлын хүрээнд эмнэлгийн халдвар хамгаалал, нэг удаагийн хэрэгсэл нөөцөлсөн, тайлант онд мал амьтадыг зах зээлийн үнээр шинээр дахин үнэлсэн нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 161.3 сая төгрөг болж 10.2 сая төгрөгөөр өсжээ. Энэ нь Коронавирус цар тахлын хүрээнд дээд шатын төсөв захирагч, бусад газраас 26.0 сая төгрөгийг үнэ төлбөргүй үндсэн хөрөнгө нэмэгдсэн нь өсөхөд гол нөлөөлжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 281.6 сая төгрөг болж 105.9 сая төгрөгөөр өссөн байна.

Наран сумын хүн эмнэлгийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 315.9 сая төгрөгөөр буюу 89 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих, нэмэлт санхүүжилтийн орлого, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого байна. Тодруулбал үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 85.5 сая төгрөгөөр өссөн, Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих 53.4 сая, нэмэлт санхүүжилтийн орлого 142.9 сая, төсвийн урсгал санхүүжилт 34.0 сая төгрөг болж өссөн нь үр дүнгийн тайлангийн орлого өсөхөд голлон нөлөөлсөн байна.

Нийт зардал өмнөх оноос 196.5 сая төгрөгөөр буюу 53 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, хоол хүнс, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал зэрэг зардлууд өссөн нөлөөлсөн байна. Энэ нь коронавирус цар тахлын үед ажилласан албан хаагчдын илүү цагаар ажилласан ажлын хөлс, хэвтэн эмчлүүлсэн иргэдийн эм, эмнэлгийн хэрэгсэл, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал нэмэгдсэнээс шалтгаалжээ

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 373.1 сая төгрөгийн төсөв баталснаас 308.5 сая төгрөгийг улсын төсвөөс, 46.8 сая төгрөгийн орон нутгийн төсвөөс, 17.9 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 308.5 сая төгрөгийг улсын төсвөөс, орон нутгийн төсвөөс 28.2 сая, 13.4 төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 342.8 сая төгрөгийг зарцуулж, 7.3 сая төгрөгийг үлдэгдэлтэй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.2 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд дээд шатны төсөв захирагчаас 149.8 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 0.4 сая, ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 8.0 сая нийт 158.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшилд 20.0 сая, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 2.9 сая, хангамж, бараа материалын зардал 10.3 сая, нормативт зардал 102.3 сая, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал 22.4 сая, нийт 157.9 сая төгрөгийн гүйцэтгэл гарч 0.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй болно.

Тайлант онд Наран сумын Засаг даргатай гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 91 хувийн биелэлттэй байна.

3.8 Аудитын гол асуудал

Наран сумын хүн эмнэлгийн үйл ажиллагаа, тайлант хугацаанд гарсан ажил гүйлгээ, үйл явдал болон засаглах эрх бүхий этгээдүүдийн түвшин дэх харилцаатай холбоотой санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудал байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын

талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Наран сумын хүн эмнэлэг нь 2021 онд нийт 604.2 сая төгрөгийн 17 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 604.2 сая төгрөгийн 17 мэдээллийг ил тод байршуулаагүй зөрчилтэй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолоор төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн 9 арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг бүх шатны байгууллагын төсөв захирагч нарт даалгасан байна. Тухайлбал:

- Тогтоолын 1.1-д “Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах”
- Тогтоолын 1.8-д “байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах; гэж заасан байна”

Сангийн яамнаас 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн “Тодруулга хүргүүлэх тухай” Н-3/845 дугаар албан бичгийг Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна. Тус албан бичигт “Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д заасан “үндсэн үйл ажиллагаатай холбоотой зайлшгүй шаардлагатай зардал, төсөл, арга хэмжээ” гэдэгт төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор ажилтан, албан хаагчдад төлж байгаа цалин хөлс, олговор, ажил олгогчоос төлөх нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, цахилгаан, халаалт, цэвэр, бохир ус, түрээсийн зардал болон байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой шаардлагатай бусад зардал хамаарна.” гэж тодруулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 16.2 сая төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт, 1 зөвлөмж, зөрчлийг арилгах 1 албан шаардлагыг биелүүлсэн байна.

Хүснэгт 2 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/сая.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	2	4.0	2	4.0	-	-	-
Албан шаардлага	-	-	-	-	-	-	-
Зөвлөмж	1	-	1	-	-	-	-
Нийт дүн	3	4.0	3	4.0	-	-	-

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Наран сумын хүн эмнэлгийн тайлант оны үйл ажиллагаа, төсвийн гүйцэтгэл, ажил гүйлгээ болон санхүүгийн тайланг тасалбар болгож гаргасан өдрөөс хойших үйл явдлыг шинжилж үзэхэд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитын явцад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг үүсээгүй .

4.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 56 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байгаа зөрчил нь УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлд тусгасан “Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх ба хэрэв хүлээлт нь өмнөх тооцооллоос өөр байвал уг өөрчлөлтийг УСНББОУС 3 тооцооллын өөрчлөлтийн дагуу тайлагнана” заалттай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийн эдийн засгийн нас буюу ашиглах хугацааг тухайн хөрөнгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоож, УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлийг мөрдөж ажиллах.

2. Шилэн данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Шилэн дансны нэгдсэн сайтад тайлант хугацаанд оруулах мэдээллээс 17 мэдээллийг мэдээлээгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг иж бүрэн, үнэн зөв байршуулж, олон нийтийг мэдээллээр хангах

3. Авлагатай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:

Эрүүл мэндийн даатгалын сангаас 2,104.3 сая төгрөгийн авлагатай, иргэн, хуулийн этгээдэд 1,015.8 сая төгрөгийн богино хугацаат өр төлбөртэй байна. 2022 оны 01 дүгээр

сард авлага бүрэн төлөгдсөн бөгөөд 1,088.5 сая төгрөгийн төсвийн үлдэгдэлтэй байна. Уг төсвийн үлдэгдлийг Төсвийн тухай хуульд заасны дагуу дээд шатны төсөв захирагч болон төсөв батлах эрх байгууллагын шийдвэрээр зарцуулагдахаар байна.

3.2 Өгсөн зөвлөмж:

Дээд шатны төсөв захирагч болон төсөвт батлах эрх бүхий байгууллагын шийдвэр гарсны дараа Төсвийн үлдэгдлийг зарцуулахыг зөвлөмж болгож байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Наран сумын Хүн эмнэлэг	3	-	-	-	-	-	-	-	3	-